

МОНГОЛ – ЯПОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ШИНЭ ЗУУНД ЭРЧИМЖҮҮЛЭХ НЬ

Б. Хулдорж¹

Өмнөтгөл

Монгол улстай маш богино хугацаанд иж бүрэн түншлэлийн харилцаанд шилжиж чадсан орон бол Япон. Монгол-Японы эрчимтэй хамтын ажиллагааны түүх ч харьцангуй богино хугацааг хамарч байна. Хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосон 1972 оноос 1990-ээд он хүртэл хамтын ажиллагаа хязгаарлагдмал байлаа. Энэ нь нэг талаас хоёр ард түмний хувьд бие биеэ сайн мэдэхгүй, ёс заншил, соёл, нийгмийн байгуулал өөр өөр байсантай холбоотойн дээр нөгөө талаас аль аль нь үзэл сурталжсан өнцгөөс бие биеэ ажиглаж байв. Үүнд өмнөх дайны асуудал ч хоёр ард түмний хувьд эмзэг сэдэв байсантай холбоотой. Нөгөөтэйгүүр Монгол улс дэлхийн социалист системтэй олон талын нягт хамтын ажиллагаатай байсан тул гадаад харилцааны гол гол асуудлаа, түүний дотор өрнөдийн орнуудтай тогтоох хамтын ажиллагааны асуудлаа хамтын нөхөрлөлийн орнуудтайгаа зөвлөлддөг дэг жаягтай байв.

Харин дэлхийн социалист систем цаашид оршин тогтнох боломжгүй болсон 1990-ээд оноос ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудаас өрнөдийн орнуудтай хийх хамтын ажиллагаанд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан нь манай хоёр орны ард түмэн ойртож, харилцан бие биеэ танихад тус дөхөм болсон. Улмаар хоёр ард түмэн шинэ зуунд хамтран ажиллах хөрс суурь аажим аажмаар бэхжиж ирсэн билээ. Өнгөрсөн хориод жилийн эдийн засгийн хамтын ажиллагааны түүхийг эргэн харахад сургамжтай, бахархалтай, басхүү чамлалттай зүйл ажиглагдаж буйд дүн шинжилгээ хийх цаг нэгэнт болжээ.

Энэхүү өгүүлэлд Монгол-Японы эдийн засгийн хамтын ажиллагааны үндэс суурь хэрхэн бүрэлдсэн болон шинэ зууны эхэнд хэрхэн хөгжиж буйг орчин үеийн эдийн засгийн дипломат зүйн шинжлэх ухааны үүднээс товчхон авч үзэхийг зорив.

Эдийн засгийн хамтын ажиллагааны шимтэй хөрс бүрдүүлсэн нь

Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш хоёр орны хооронд улс төрийн яриа хэлцэл явагдаж байсан боловч 1970-аад он хүртэл дорвитой алхам хийгдээгүй юм. Харин 70-аад оноос хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох талаар Варшав, Москвад суугаа Элчин сайдын яамдаараа дамжуулан идэвхтэй ажилласнаас гадна албаны төлөөлөгчдөө харилцан солилцож, дайны төлбөр, хоёр орны дайны тухай байдлыг цуцлах зэрэг арга хэмжээг авсны үр дүнд Улаанбаатар, Токио хотуудад Элчин сайдын яамдаа нээснээр хоёр орны харилцаанд чанарын шинэ алхам хийлээ. Үүнд хоёр талын санаачлага, харилцан ойлголцох чин хүсэл эрмэлзэл

¹ МУИС. ОУХС-ийн профессор, доктор (Ph.D)

давамгайлж байсныг тэмдэглэх нь зүйтэй юм². Улмаар аль аль тал нь хоёр орны харилцааг идэвхжүүлэх бодитой арга зам эрэлхийлж, харилцан тохиролцсон анхны томоохон төсөл нь одоо ч Монголын эдийн засагт хүндтэй байраа хадгалсаар байгаа Говь үйлдвэр. Энэ бол Монголын ноолуурыг зах зээлийн нүдээр харж, ямар үнэ цэнэтэй, хосгүй түүхий эд болохыг монголчууд бидэнд ойлгуулсан төсөл билээ. Энэ цаг мөчөөс эхлэн ноолуур дотооддоо үнэд хүрч, малчдын амьжиргааны нэг гол эх үүсвэр болох зам нээгдсэн юм.

Өнгөрсөн зууны 80-аад оны сүүлч, 90-ээд оны эхээр дэлхийн нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтолцоонд гарсан өөрчлөлт олон улсын харилцаанд ч тусгалаа олов. ЗХУ тэргүүтэй социалист орнуудын цэрэг-улс төрийн нэгдсэн бүтэц нь задран унамагц Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл аяндаа татан буугдав.

Монгол улсын худалдаа эдийн засгийн уламжлалт түншүүд хуучин хэлбэр, уламжлалаараа хамтын ажиллагаагаа цаашид явуулах боломжгүй болсон тул хэн хэн нь шинэ түнш хайж, хамтын ажиллагааны шинэ хэлбэр, зарчимд суралцах зайлшгүй шаардлагатай тулгарав. Өөр хаа нэгтэйгээс туршлага судлах, хэн нэгнээс зөвлөгөө авах боломж байсангүй. Бүхий л асуудлыг тус бүртээ өөрийнхөөрөө шийдвэрлэхээс өөр сонголт үлдсэнгүй.

Манай орны олон улсын харилцаанд тээг болж байсан ЗХУ-ын хориг алга болсноор АНУ, БНСУ, Австрали зэрэг хөрөнгөтөн орон, ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон улсын байгууллагатай эдийн засгийн харилцаа шинээр тогтоож өргөн хүрээтэй хамтран ажиллах боломж нээгдлээ.

Өмнөд хөрштэйгээ ч худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагаагаа сэргээж эхэллээ. Түүхийн ийм сорилттой нүүр учран өрнөдтэй шинэ түншлэл бий болгох эхний үед Японы Засгийн газар тэдгээр орноос хамгийн түрүүнд зах зээлд шилжих шилжилтийн эхлэлийг амжилттай тавихад нэн чухал туслалцаа үзүүлсэн билээ. Ялангуяа Дэлхийн банк, ОУВС-д элсэхэд тус дэмжлэг үзүүлсэн төдийгүй, Монголд өрнөсөн нийгмийн өөрчлөлтийн тухай, Монгол улсад тусламж үзүүлэх шаардлагатай тухай асуудлыг 1990 онд Хьюстонд, 1991 онд Лондонд болсон Их долоогийн уулзалтын баримт бичигт тусгахад Японы Ерөнхий сайд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байдаг.

Япон улс манай улсын экспортод тавдугаар байрт, худалдааны нийт эргэлтээр ОХУ, БНХАУ-ын дараа гуравдугаарт³, импортод ОХУ, БНХАУ, АНУ-ын дараа дөрөвдүгээрт⁴ орсон амжилтаар өнгөрсөн зууныг үдлээ (Хүснэгт 1, Бүдүүвч 1, Хүснэгт 3).

Хүснэгт 1. Өнгөрсөн зууны төгсгөл дэх хоёр орны гадаад худалдаа (сая ам. доллар)

	1990	1991	1993	1995	1997	1999
Экспорт	7.6	10.8	17.01	95.34	37.66	10.89
Импорт	10.0	2.76	20.76	45.26	34.67	115.2
Нийт	17.6	13.56	37.77	140.6	72.33	125.91

² Монгол Японы харилцаа: эрт эдүгээ, УБ, 2001, 138-159 дахь тал.

³ Монгол Японы харилцаа: эрт эдүгээ, УБ, 2001, 277 дахь тал: худалдааны эргэлтээр гуравдугаарт байгааг дөрөвдүгээрт гэж ташаарсан байна.

⁴ Б. Сэржав, Монгол-Японы харилцаа XX зууны сүүлийн хагаст, УБ, 2003, 93 дахь тал: импортоор дөрөвдүгээрт байгааг гуравдугаарт гэж ташаарсан байна.

тушаалын хүмүүст ч энэ талаараа ярьж, албан баримт бичигт тусгасан нь бий. Тухайлбал, 1997 оны 2–дугаар сард Японд хийсэн Ерөнхий сайд М. Энхсайханы айлчлалын үеэр Японы тал хөрөнгө оруулалтын нөхцлийг сайжруулах, нэгэнт орсон хөрөнгийг хамгаалах, Японы засгийн газрын хөрөнгөөр бий болсон объектыг хувьчлахгүй байх, зээл, тусламжийн өгөөжийг дээшлүүлэх, тусламжийн хөрөнгөөр эргэлтийн сан байгуулах талаар Монголын тал сайн анхаарахгүй байгааг шүүмжлээд хамтарсан мэдэгдэлд “...Япон улсын дэмжлэг тусламжийг үр өгөөжтэй ашиглаж бие даасан хөгжлөө хангахын тулд улам их хүчин чармайлт гаргана гэдэгт найдаж” байгаагаа илэрхийлжээ. Энэ бол хоёр талын хамтын ажиллагааг “сүүлийн жилүүдэд эрчимтэй хурдан хөгжиж байна. Энэхүү нэн сайн харилцааг ирэх XXI зуунд улам бүр өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө цаашид ч хичээнгүйлэн чармайлх өндөр хариуцлагатай үүрэг талуудад ногдож байна⁸” гэж дүгнэсэн айлчлал байлаа. Шинэ зуунд талууд хэрхэн ажиллаж байна вэ?

Шинэ зууны Монгол-Японы эдийн засгийн дипломат ажиллагаа

Ийнхүү өнгөрсөн зууны төгсгөлд эх суурь нь эрчимтэй тавигдсан хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа шинэ зуунд гараагаа хэрхэн эхэлснийг хоёр болон олон талын эдийн засгийн дипломат зүйн үүднээс: а) хоёр орны гадаад худалдаа; б) хөрөнгө оруулалт; в) зээл, тусламж, техникийн хамтын ажиллагаа; нэмэлт болгон г) аялал жуулчлал гэсэн чиглэлээр авч үзье. Ингэхдээ Зүүн хойт Азийн бүс нутгийн орнуудтай харьцуулна.

А) Гадаад худалдаа

Шинэ зуунд шинэ түншүүдтэйгээ хийж буй гадаад худалдааны нийт эргэлт тасралтгүй өссөөр байна. Ялангуяа Монгол улсын эдийн засгийн хамтын ажиллагаа Зүүн хойт Азийн бүсийн орнуудад төвлөрөх болжээ. Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 77.3 хувь нь энэ бүс нутгийн орнуудад ногдох болсон нь үүнийг нотолно (Хүснэгт 3).


Хүснэгт 3. Монгол улсын гадаад худалдааны өнөөгийн байдал (хувиар)

	1999		2001		2003		2005		2007		2008	
	хувь	байр	хувь	байр	хувь	байр	хувь	байр	хувь	байр	хувь	байр
БНХАУ	30.0	I	32.0	I	34.0	I	36.5	I	49.4	I	43.9	I
ОХУ	21.0	II	24.0	II	22.0	II	19.8	II	19.5	II	23.0	II
АНУ	12.0	IV	14.0	III	12.0	III	8.6	III	3.8	IV	0.03	IV
Япон	13.0	III	6.0	V	5.1	V	3.62	V	3.8	IV	0.04	III
БНСУ	4.0	V	7.0	IV	3.0	IV	5.7	IV	3.9	III	0.04	III
ХБНГУ	3.5	VI	3.5	VI	3.5	VI	0.2	VI	2.2	VI	0.02	V

Дээрх хүснэгт, бүдүүвчээс харахад БНХАУ-тай хийж буй худалдаа эрчимтэй өсч байгаа бол Япон улс өнгөрсөн зуунд хүрсэн түвшингээсээ тасралтгүй ухарсаар байна. Өөрөөр хэлбэл манай орны гадаад худалдааны өсөлтөд Япон улсын 1990–ээд оны эхэнд эзэлж байсан байр суурийг БНХАУ аажмаар нөхөх болсон байна. Тухайлбал, Монгол–Японы худалдааны эргэлтийн эзлэх хувь энэ хугацаанд 3 дахин буурч, манай худалдааны гуравдагч гол түншийнхээ байрыг БНСУ, АНУ–д тавьж өгч байна (харин 2008 оны үзүүлэлт хуучин хандлага руугаа өөрчлөгдөх найдлага төрүүлж байна). Өнгөрсөн зууны төгсгөлд Монгол–Японы худалдааны нийт хэмжээ Монгол–Хятадын худалдаанаас 3 дахин, Монгол–Оросын худалдаанаас 2 дахин бага байсан бол 2009 оны байдлаар энэ зөрүү харгалзан 17 дахин, 7 дахин бага болж буурчээ. Энэ нь Монгол–Оросын гадаад худалдааны хэмжээ харьцангуй тогтвортой, харин Монгол–Хятадын худалдаа эрчимтэй нэмэгдэж, Монгол–Японы худалдаа эрс багасч байгааг харуулж байна.

⁸ Мөн тэнд. 238 дахь тал

Бүдүүвч 2



Монгол улсын гадаад худалдааны эргэлтэд импорт дийлэнх хувийг эзэлсэн хэвээр байна. Иймд импортын түншүүд манай эдийн засгийн гадаад харилцаанд чухал байр суурь эзэлнэ. Өсөн нэмэгдэж буй дотоод хэрэгцээгээ Монгол улс импортоороо хангаж ирсэн бөгөөд энэ байдал нэг хэсэгтээ хадгалагдах нь тодорхой байна. Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш манай улсын импортын түншүүдэд онц өөрчлөлт орсонгүй (Хүснэгт 4). Төмс, хүнсний ногооны дотоод хэрэгцээгээ 2008 оноос өөрөө хангадаг болсноор БНХАУ-аас авдаг импортын хэмжээ багасч, харин нефть бүтээгдэхүүний үнийн өсөлт ОХУ – аас авдаг импортын үнийн дүнг нэмэгдүүлж улмаар импортын гол түншүүдийн байрт өөрчлөлт оруулж байна. БНХАУ тэргүүлэх байраа ОХУ-д алдсан байна.

Хүснэгт 4. Монгол улсын импортын гол түнш (хувиар)

	1999		2001		2003		2005		2007		2008	
	хувь	байр	хувь	байр	хувь	байр	хувь	байр	хувь	байр	хувь	байр
БНХАУ	28.0	I	36.0	I	33.0	I	35.3	I	34.6	I	28.2	II
ОХУ	15.0	III	22.0	II	24.5	II	26.0	II	31.7	II	38.3	I
АНУ	22.0	II	9.0	III	8.0	IV	6.4	IV	6.0	III	2.6	VI
Япон	7.0	IV	9.0	IV	8.5	III	5.4	V	5.5	IV	7.5	III
БНСУ	5.0	V	5.0	V	5.0	V	3.2	VI	3.6	V	5.8	IV
ХБНГУ							8.6	III	2.7	VI	2.9	V

2008 оны үзүүлэлт⁹

Гэхдээ импортын гол түншүүдийн эзлэх байр суурьт БНХАУ тэргүүлэх байр сууриа итгэлтэйгээр хадгалж байгаа бол ОХУ-ын импортын эзлэх хувь шинэ зууны эхний 8 жилд 2.3 дахин өсч, 2 дугаар байрт баттай зогссон төдийгүй өнгөрсөн жилээс эхний байрт шилжиж амжсан байна. ОХУ-д байр сууриа алдсан хэдий ч АНУ, Япон манай импортын гуравдагч, дөрөвдөгч түншийн байртайгаа үндсэндээ эвлэрч байна гэж дүгнэж болох юм. АНУ 2008 онд сүүлийн байр луу ухарсан ч энэ нь нэг их удаан үргэлжлэхгүй болов уу. Гэхдээ дээрх хүснэгтэд ХБНГУ-аар төлөөлүүлж байгаа Европын холбоо Монгол улстай худалдаагаа өргөжүүлэх талаар ихээхэн сонирхолтойгоо илэрхийлж манай оронд худалдааны таатай нөхцөл олгох яриа хэлцэл хийгдэж байгаагаас үзэхэд ойрын ирээдүйд Монгол улсын гол импортлогчдын бүтцэд мэдэгдэхүйц өөрчлөлт орж болзошгүй байна.



Б) Хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ шинэ зууны эхнээс тогтвортой өсч байгааг дараах бүдүүвчээс харж болно (Бүдүүвч 3). Гол хөрөнгө оруулагчдын эзлэх хувийн жингийн өнөөгийн байдлын өөрчлөлтийг харьцуулан үзүүлэх үүднээс Бүдүүвч 4-өөр 2005 оны хөрөнгө оруулагчдын эзлэх хувийн жинг үзүүлэв.

⁹ www.statist.mn/bull/2008/bulletin_dec/2008

Бүдүүвч 3

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (сая ам дол) Гол хөрөнгө оруулагч түншүүд (2005 он)




Япон улсын хөрөнгө оруулалт өнгөрсөн зууны сүүлийн 10 жилтэй харьцуулахад үндсэндээ зогсонги байдалд орсон төдийгүй хөрөнгө оруулалтад эзлэх хувийн жин нь буурах хандлагатай болжээ. Харин 2008 оноос шинэ онгоцны буудлын төслийг эхлүүлснээр хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ Япон улс хоёрдугаар байртай буцаж очлоо. Үүнээс өмнө Японы хөрөнгө оруулалтын хувь хөрөнгө оруулагчид дотор 5–7 дугаар байр луу ягуухан ухарсаар байсныг Хүснэгт 5 харуулж байна.

Хүснэгт 5. Монголын гол хөрөнгө оруулагч түншүүд (хувиар)

	2000		2002		2004		2006		2008	
	хувь	байр	хувь	байр	хувь	байр	хувь	байр	хувь	байр
БНХАУ	35,1	I	78,5	I	53,2	I	54,3	I	70,2	I
ОХУ	2,6	V	0,9	VI	0,9	VII	0,3	IX	0,5	VIII
АНУ	8,0	IV	1,5	V	1,4	VI	10,0	III	1,0	VII
Япон	18,0	II	1,5	V	2,3	V	1,3	VII	6,6	II
БНСУ	12,0	III	9,0	II	2,7	IV	4,5	IV	5,9	III
Канад	-		2,6	III	22,0	II	20,0	II	0,4	IX
Их Британи	8,0*	IV	1,7*	IV	10,0*	III	4,0*	V	2,0*	VI
Сингапур	-	-	-	-	-	-	1,5**	VI	4,6	V
Ксйман арал	-	-	-	-	-	-	0,7	VIII	5,0	IV

*Верджини арлуудыг оролцуулаад; **2005 оны байдлаар

Бүдүүвч 5. Гол хөрөнгө оруулагч түншүүд (2008 оны байдлаар)



Өнгөрсөн 10 жилийн дотор нийт хөрөнгө оруулагч орны тоо 2000 онд 42 байсан бол 2008 онд 52¹⁰ болж 25,0 хувиар нэмэгдсэн төдийгүй хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 2008 онд 2000 оныхоос 7,5 дахин нэмэгдэж 708,9 сая ам долларт хүрчээ. Үүнээс БНХАУ байр сууриа улам бэхжүүлж нийт хөрөнгө оруулалтын 2/3 илүү хувийг эзлэх болжээ. Уул уурхай, газрын тос, барилга, зам зэрэг хөрөнгө оруулалт их шаарддаг салбарт хөрөнгө оруулалт хийж байна. Өнгөрсөн 3 жилийн дотор гол хөрөнгө оруулагчдын байр, эзлэх хувь, бүтцэд гарч байгаа өөрчлөлтийг харьцуулан харах боломж олгох үүднээс Бүдүүвч 4–ийг 2005 оны байдлаар Бүдүүвч 5–ыг 2008 оны байдлаар харуулав. Хөрөнгө оруулалтын хуучин түншүүдийн хажуугаар Сингапур, Кейманы арал шийдэмгий орж ирж байна.

В) Зээл, тусламж, техникийн хамтын ажиллагаа

Монгол улс гол хандивлагч орон, олон улсын байгууллагатайгаа түншлэлийн ихээхэн туршлага хуримтлуулсан үр дүнтэйгээр шинэ зуунтай золголоо. Хамтран ажиллах арга, хэлбэрээ ч олж хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламж авахдаа түншлэлийн харилцааг илүү эрхэмлэдэг болов. Үүнд япон нөхдийн заавар, зөвлөмж мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэсэн.

Хүснэгт 5. Шинэ зуунд Японы засгийн газраас олгосон зээл тусламж (100 сая иен) ¹¹

	Буцалтгүй тусламж	Хөнгөлттэй зээл	Техникийн хамтын ажиллагаа	Нийт тусламж
2000	65.68	61.39	173.01	300.08
2002	40.6	-	128.28	168.88
2004	18.8	-	108.26	127.06
2006	58.28	29.81*	132.03	220.12
2008	41.37**	288.07**	225.89**	555.33**

*2005 оны мэдээ; ** 2007 оны мэдээ¹²

Японы засгийн газраас үзүүлж буй буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээл, техникийн хамтын ажиллагааны хэмжээ хумигдах хандлагатай болсон нь дээрх хүснэгтээс харагдана. Сүүлийн нэг жилд зээл, тусламжийн хэмжээ эрс нэмэгдсэн нь шинэ онгоцны буудал барих

¹⁰ Монгол улсын 2008 оны статистик мэдээгээр Монголд нийтдээ 101 орон хөрөнгө оруулалт хийжээ.

¹¹ <http://www.mn.emb-japan.go.jp/news/oda>; and

http://www.mofa.go.jp/policy/oda/region/e_asia/Mongolia.pdf


¹² http://www.mofa.go.jp/policy/oda/data/01ap_ea01html#mongolia

төслийн хөнгөлттэй зээл, техникийн хамтын ажиллагаа эхэлсэнтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, өндөр өртөг бүхий нэг л төслийн нөлөө юм. Цаашдаа хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламжийн үр ашгийг дээшлүүлж, төсөл хэрэгжүүлэх салбар, хэлбэрийн сонголтыг оновчтой болгох шаардлагатай болохыг ерөнхий хандлага тодорхойлж байна.

Хоёр орны эдийн засгийн харилцааны нэн чухал дээрх бүрэлдэхүүн хэсэг шинэ зууны эхнээс буурах хандлагатай болсонд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байж болох юм. Үүнд, нэгдүгээрт, Японы ард түмнээс өнгөрсөн зуунд үзүүлсэн тусламжийн үр ашиг төдийлөн өндөр байж чадаагүй. Зах зээлийн нөхцөлд дасан зохицоод цаашдаа биеэ даах чадварыг монголчууд бид эзэмшиж чадсангүй. Төрийн албаны тогтолцоог цэгцтэй болгох чиглэлээр Японы Засгийн газрын хөрөнгөөр туршлага судалж, мэргэжил дээшлүүлсэн чиглэсэн зорилготой бэлтгэгдсэн төрийн албан хаагчид өнөөдөр хаана алба залгуулж явна аа? Японы засгийн газрын хөрөнгөөр баригдсан объектыг яагаад түншийнхээ саналаас зөрөөд хувьчилчихав аа? Өөрөөр хэлбэл, Монголын тал олдсон боломжоо ашиглах талаар санаачлага гаргаагүйгээс тусламжийн хөрөнгийн урсгал чиглэлээ өөрчилжээ.

Хоёрдугаарт, Японы засгийн газрын дэмжлэгийг авах урт хугацааны цэгцтэй бодлогоо манай тал өнөө хүртэл боловсруулж чадсангүй. Японы талын саналыг хүлээх, сайндаа л хоорондоо авцалдаагүй, түймэр унтраахад чиглэгдсэн “мөрөөдлийн жагсаалт” гаргаж нөгөө талдаа тавьж бэлэнчилсээр байгаа нь түншээ “залхаахад” хүргэжээ. Японы тал 2004 онд Монголд үзүүлэх тусламжийнхаа бодлогыг тодорхойлоод Гадаад хэргийн яамныхаа вэб хуудсанд англи, япон, монгол хэлээр байршуулаад өнөө хүрч байгаа боловч үүн дээр нь дөрөөлөөд манай талын боловсруулсан бодлого одоо ч гараагүй байна (Бүдүүвч 6)¹³. Энэ талаар ажил эхлүүлэхэд эрдэм шинжилгээ сургалтын байгууллагын чадавхи, бололцоог ашиглан Япон улсаас Монгол улсад үзүүлэх хөгжлийн албан ёсны тусламжийн хөтөлбөр боловсруулах талаар судалгаа хийлгэх, хөтөлбөр төлөвлөгөөний төслийн уралдаан зарлах зэргээр ажиллах боломж байна.

Бүдүүвч 6. Япон улсаас Монгол улсад үзүүлэх хөгжлийн албан ёсны тусламж¹⁴




Гуравдугаарт, Монгол улсын засгийн газар буцалтгүй тусламжийн асуудлыг сүүлийн жилүүдэд урсгалд нь орхисон гэж үзэж болно. 50.0-70.0 сая ам. долларын буцалтгүй тусламж орж ирж байна. Энэ хөрөнгийг ашиглах гэрээ хэлцэл байгуулах, тухайн орнуудтай Монголын хөгжлийн шаардлага, чиглэлтэй уялдуулан санал тавих, орон зай, цаг хугацааны уялдааг хангасан буцалтгүй тусламжийн хөтөлбөрийг орон тус бүрээр боловсруулж мөрдөх ажил орхигдсон.

Гадаад орнууд өөрсдийн санаачлагаар Монголын нөхцөл байдлыг судалж, төслийн санал дэвшүүлэн засгийн газраараа батлуулан ажилладаг дэг жаяг нэгэнт тогтоод байна. Ийм

¹³ http://www.mofa.go.jp/policy/oda/region/e_asia/Mongolia.pdf

¹⁴ Англи эхийг барьж монгол орчуулгад тодотгол хийв



Өнгөрсөн 10 жилийн дотор нийт хөрөнгө оруулагч орны тоо 2000 онд 42 байсан бол 2008 онд 52¹⁰ болж 25,0 хувиар нэмэгдсэн төдийгүй хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 2008 онд 2000 оныхоос 7,5 дахин нэмэгдэж 708,9 сая ам долларт хүрчээ. Үүнээс БНХАУ байр сууриа улам бэхжүүлж нийт хөрөнгө оруулалтын 2/3 илүү хувийг эзлэх болжээ. Уул уурхай, газрын тос, барилга, зам зэрэг хөрөнгө оруулалт их шаарддаг салбарт хөрөнгө оруулалт хийж байна. Өнгөрсөн 3 жилийн дотор гол хөрөнгө оруулагчдын байр, эзлэх хувь, бүтцэд гарч байгаа өөрчлөлтийг харьцуулан харах боломж олгох үүднээс Бүдүүвч 4-ийг 2005 оны байдлаар Бүдүүвч 5-ыг 2008 оны байдлаар харуулав. Хөрөнгө оруулалтын хуучин түншүүдийн хажуугаар Сингапур, Кейманы арал шийдэмгий орж ирж байна.

В) Зээл, тусламж, техникийн хамтын ажиллагаа

Монгол улс гол хандивлагч орон, олон улсын байгууллагатайгаа түншлэлийн ихээхэн туршлага хуримтлуулсан үр дүнтэйгээр шинэ зуунтай золголоо. Хамтран ажиллах арга, хэлбэрээ ч олж хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламж авахдаа түншлэлийн харилцааг илүү эрхэмлэдэг болов. Үүнд япон нөхдийн заавар, зөвлөмж мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэсэн.

Хүснэгт 5. Шинэ зуунд Японы засгийн газраас олгосон зээл тусламж (100 сая иен)¹¹

	Буцалтгүй тусламж	Хөнгөлттэй зээл	Техникийн хамтын ажиллагаа	Нийт тусламж
2000	65.68	61.39	173.01	300.08
2002	40.6	-	128.28	168.88
2004	18.8	-	108.26	127.06
2006	58.28	29.81*	132.03	220.12
2008	41.37**	288.07**	225.89**	555.33**

*2005 оны мэдээ; ** 2007 оны мэдээ¹²

Японы засгийн газраас үзүүлж буй буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээл, техникийн хамтын ажиллагааны хэмжээ хумигдах хандлагатай болсон нь дээрх хүснэгтээс харагдана. Сүүлийн нэг жилд зээл, тусламжийн хэмжээ эрс нэмэгдсэн нь шинэ онгоцны буудал барих

¹⁰ Монгол улсын 2008 оны статистик мэдээгээр Монголд нийтдээ 101 орон хөрөнгө оруулалт хийжээ.

¹¹ <http://www.mn.emb-japan.go.jp/news/oda>; and

http://www.mofa.go.jp/policy/oda/region/e_asia/Mongolia.pdf

¹² http://www.mofa.go.jp/policy/oda/data/01ap_ea01html#mongolia

төслүүдийн үлэмж хэсэг нь Монголын талтай байгуулсан гэрээгүй байна.

Дөрөвдүгээрт, нэгэнт Монголын төрийн зүгээс энэ асуудлыг урсгалаар нь орхисон учраас буцалтгүй тусламжийн төсөл дээр гадаадын иргэдийг өндөр цалингаар ажиллуулж тусламжийн хөрөнгийн нилээд хэсэг нь буцаад гадагшаа урсч байна. Буцалтгүй тусламжийн төслийг хэрэгжүүлэх манай Засгийн газрын байгууллагуудын чадавхи сул, төрийн бус байгууллагууд нь ихэнхдээ төсөл хэрэгжүүлэх хэмжээнд бэхжиж амжаагүй байгаа гэдэг нэгдсэн дүгнэлтэд хандивлагчид хүрээд байна. Иймд төсөл хэрэгжүүлэгчээр өөрсдийн орны төрийн бус байгууллагыг (ихэнхдээ шашны байгууллагыг) Монголд оруулж ирэх хандлага газар авч байна.

Тавдугаарт, олон талын техникийн хамтын ажиллагаа, түүний дотор, технологи, мэргэжилтэн солилцох, хөгжиж буй орнуудад туршлага судлах зэрэг бүтээлч хэлбэрүүд хүрээгээ хумьсан байна. Өнгөрсөн 1990-ээд оны эхээр Хөгжиж буй орнуудын техникийн хамтын ажиллагааны байгууллагатай (TCDC) тогтоосон харилцаа одоо нэгэнт мартагдаад байгаа нь харамсалтай. Гэтэл энэ хүрээнд өнгөрсөн зуунд хуримтлуулсан туршлага үлэмж, байгууллагуудын хооронд тогтоосон харилцаа чамлалтгүй байсныг сэргээвэл буцалтгүй тусламжийн үр ашиг мэдэгдэхүйц дээшлэх боломж байна. Хандивлагч орон, олон улсын байгууллага ч энэ чиглэлд манай талын хийх алхамыг хүлээсээр байна.

Дүгнэлт

Монгол улсыг зах зээлийн эдийн засгийн хүнд сорилттой нүүр тулан барьц алдахад Японы ард түмэн, Япон улсын засгийн газар хамгийн түрүүнд гараа сунгасан. Хүнсний картан үеийг даван гарч, гадаад түншээ олж авах, тэдэнтэй худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа явуулах гарааны нөхцлийг бүрдүүлэхэд Японы Засгийн газрын үзүүлсэн нөлөө их. XX зууны сүүлийн арван жил манай орны хувьд зах зээлд шилжих шилжилтийн үе, худалдаа эдийн засгийн шинэ харилцаа үүсэн бүрэлдэх үе, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллага, хандивлагч оронтой харилцаа тогтоож хамтын ажиллагаа эхлүүлэх үе, дэлхий нийтэд өөрийгөө таниулж, нээлттэй ажиллах үе байлаа.

Энэ үед олон улсын байгууллага, хандивлагч орон, түүний дотор Япон улс манай оронтой худалдаа, эдийн засгийн харилцаагаа эрчимтэй хөгжүүлж, шилжилтийг хүндрэл багатай даван туулахад бүхий л хүчин чармайлтаа чиглүүлж байсныг статистикийн тоон мэдээлэл нотолж байна.

Шинэ зууны эхний жилүүдэд өмнөх хамтын ажиллагааны ололт амжилт саарсанд талууд, ялангуяа Монголын тал дүгнэлт хийх ёстой. Харамсалтай нь Монголын засаг, төр алдаа, дутагдлаа эргэн харж, дүгнэлт хийх чадваргүй болсны харгайгаар хүрсэн амжилтаа ахиулах, ядахдаа хүрсэн түвшинд нь байлгах талаар бараг арга хэмжээ авсангүй. Энэ нь Монголын төр, Засгийн газар, тэнд ажиллагсдын мэдлэг чадвар дорой, туршлага хомс, санаачлага сул, хариуцсан ажил салбарынхаа хөгжлийн асуудлыг боловсруулах чадваргүй, бэлэнчлэх сэтгэлгээнд идэгдсэнтэй холбохоос өөр гарцгүй мэт. Энэ нь төр засгийн байгууллагын хүний нөөцийн бодлогод шийдвэртэй өөрчлөлт хийх хэрэгтэйг харуулж байна. Нөгөөтэйгүүр, буцалтгүй тусламжийн хөрөнгийг нэг удаа түймэр унтраах хэлбэрээр биш, дараагийн өөр төсөл санхүүжүүлэхэд зориулахын тулд эргэлтийн сан байгуулж ажиллах нь чухал юм. Японы тал ч үүнийг хүсч байсныг дээр дурдсан билээ.

Иймд Монгол-Японы шинэ зууны эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар алсыг харсан цэгцтэй бодлого боловсруулж мөрдөх, түүнийгээ хэрэгжүүлэх цогц арга хэмжээг төлөвлөх, бусад орон, олон улсын байгууллагатай явуулах хамтын ажиллагаатай уялдуулах цаг болжээ. Энэ асуудлыг Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо гартаа авч улс орны хөгжлийн бодлоготой уялдуулбал зохино. Зээл гэдэг зөвхөн мөнгөний эргэн төлөх тооцоо төдий зүйл биш юм. Өөрөөр хэлбэл, авч байгаа хөнгөлттэй зээлийг хандивлагч тус бүрийн дотоод журам, зээл олгодог чиглэл, хөгжлийн бусад салбарын бодлоготой уялдуулж байж үр ашгийг нь дээшлүүлнэ. Буцалтгүй тусламж хөрөнгийн эргэн төлөлттэй ямар ч холбоогүй

байдаг нь санхүүгийн бодлого барьдаг байгууллагын үйл ажиллагаатай бүр ч холбоогүй. Сангийн сайдын эрхлэх ажлын хүрээнд энэ үйл ажиллагааг зохицуулах нь үр ашиг муутай гэдгийг шинэ зууны эхний 10 жил нэгэнт нотоллоо. Хандивлагчид өгсөн хөрөнгөө үр ашигтай зарцуулах механизмыг бүрдүүлэх зорилгоор санаачилсан Парисын тунхаглалын зарчмаар ажиллахыг дэлхий нийт биднээс хүсч байна.

Хандивлагчидтай хийх хамтын ажиллагаа, зээл, тусламжийн байгууллагыг нэг яамны хавсрага маягаар нэр төдий байлгах нь талуудын аль алиных нь сонирхолд нийцэхгүй байгаа төдийгүй хөрөнгө, хүн хүчний асар их бололцоог алдагдахад хүргэж байна. Хандивлагчид хөгжиж буй оронд тусламж үзүүлэх байгууллагаа (USAID, AUSAID, CIDA, SDC, GTZ, JAIKA, KOICA гэх мэт) бие даасан хэлбэрээр байгуулаад байхад тусламжийг нь хүртдэг манай улс үл тоож суух нь зүйд нийцмээргүй. Ийм бие даасан байгууллага л яваандаа бусдад тусламж үзүүлэх байгууллага болон өсч өндийдөг. АНУ-аас үзүүлсэн тусламжийн хөрөнгийг хэрхэн зөв зарцуулж эргэлтийн хөрөнгө босгон улмаар өөрөө тусламжийн байгууллага болсон Койкагийн туршлага ийм ажээ.